

Хоёр товчлуур

Вася нэгэн сонин төхөөрөмж олж гэнэ. Төхөөрөмжийн урд хэсэгт улаан болон цэнхэр хоёр товчлуур байх ба дэлгэцэн дээр ямар нэгэн бүхэл тоог харуулна. Улаан товчлуурыг дарвал дэлгэцэн дээрх тоо хоёр дахин ихэснэ. Цэнхэр товчлуурыг дарвал дэлгэцэн дээрх тоо нэгээр хорогдоно. Дэлгэцэн дээрх тоо сөрөг болбол төхөөрөмж эвдэрнэ. Дэлгэц ямар ч том тоог гаргаж чадна. Анх дэлгэцэн дээр n гэсэн тоо байсан.

Боб дэлгэцэн дээр m гэсэн тоог гаргахыг хүсчээ. Түүний тулд хамгийн багадаа хэдэн удаа товчлууруудыг дарах хэрэгтэй вэ?

Оролт

Оролтын эхний мөрөнд n болон m ($1 \leq n, m \leq 10^4$) гэсэн ялгаатай бүхэл тоонууд зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

Гаралт

Хамгийн багадаа хэдэн удаа товчлууруудыг даран n тоог m болгож болохыг хэвлэ.

Жишээ

Оролт 1 :

4 6

Гаралт 1 :

2

Оролт 2 :

10 1

Гаралт 2 :

9

Тайлбар

Эхний жишээнд цэнхэр товчлуурыг нэг удаа даран, улаан товчлуурыг 1 удаа дарна.

Хоёр дахь жишээнд тоог хоёр дахин нэмэгдүүлэх шаардлагагүй тул цэнхэр товчлуурыг есөн удаа дарна.

Орчуулсан : Б.Даваабаяр